



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/255

Есөнбулаг сум

Орон нутгийн зөвлөл
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дүгээр хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалт, Японы Хүүхдийг ивээх сан, Говь-Алтай аймгийн засаг дарга хооронд 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан "Харилцан ойлголцлын санамж бичиг"-ийн 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Японы Хүүхдийг Ивээх Сангийн хэрэгжүүлж буй "Суралцахад ээлтэй, хүртээмжтэй сургууль" төслийг удирдан чиглүүлэх үүрэг бүхий "Орон нутгийн зөвлөл"-ийг байгуулж, бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар чиг үүргийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Зөвлөлийн дүрэм, үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж үр дүнг Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд хагас, бүтэн жилээр тайлагнан ажиллахыг аймгийн Засаг даргын Нийгмийн салбарын төсөл, хөтөлбөрийн удирдагч (Э.Энхнаран)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны
... дугаар сарын ... ны өдрийн ... дүгээр
захирамжийн нэгдүгээр хавсралт

**"СУРАЛЦАХАД ЭЭЛТЭЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ СУРГУУЛЬ" ТӨСЛИЙН
ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Зөвлөлийн дарга: Аймгийн Засаг даргын Нийгмийн салбарын төсөл,
хөтөлбөрийн удирдагч

Гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн дарга
Аймгийн Засаг даргын Хөвлөлийн албаны дарга
Аймгийн Боловсролын газрын дарга
Аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрын
дарга
Есөнбүлэг сумын Засаг даргын Тамгын газрын нийгмийн
бодлогын мэргэжилтэн
Есөнбүлэг сумын Ерөнхий боловсролын 1,2,3 дугаар
сургуулийн захирлууд
Шарга сумын Засаг дарга
Шарга сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал

Нарийн бичгийн дарга: Хүүхдийг Ивээх Сангийн Говь-Алтай аймаг дахь
төслийн ажилтан

__ оОо __

Аймгийн Засаг даргын 2026 оны
05 дугаар сарын 12 ны өдрийн 1 дүгээр
захирамжийн хоёрдугаар хавсралт

**"СУРАЛЦАХАД ЭЭЛТЭЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ СУРГУУЛЬ" ТӨСЛИЙН
ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨЛИЙН ЧИГ ҮҮРЭГ**

№	Албан тушаал	Ажил үүргийн чиглэл
1	ТОНЗ-ийн дарга, Аймгийн Засаг даргын Нийгмийн салбарын төсөл, хөтөлбөрийн удирдагч	- Төслийн орон нутгийн зөвлөлийн /ТОНЗ/ үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, гишүүдийн ажлын уялдаа холбоо, оролцоо, хамтын ажиллагааг хангах, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох - Аймгийн бодлого, төлөвлөгөөтэй төслийн үйл ажиллагааг уялдуулах, аймгийн хэмжээнд сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, тогтвортой байдлыг хангах - Төслийн орон нутгийн зөвлөлийн хурлыг улиралд 1 удаа тогтмол хуралдуулах, төслийн зорилго, зорилт, үйл ажиллагаа, үр дүнгийн талаарх мэдээллийг аймгийн иргэд болон бусад холбогдох талуудад дэлгэрэнгүй танилцуулах, орон нутгийн хэвлэл мэдээллийн сувгаар нээлттэй, хүртээмжтэй байдлаар тогтмол мэдээлэх ажлыг удирдан чиглүүлэх - Төсөл хэрэгжиж буй сумдын Засаг дарга бөгөөд хамтарсан багийн ахлагч нарын Аймгийн Засаг даргатай байгуулах үр дүнгийн гэрээнд төслийг чанартай хэрэгжүүлэх, шаардлагатай дэмжлэгийг тогтмол үзүүлэх талаар тусгах - Төслийн хэрэгжилтийн явцтай танилцах, хяналт-үнэлгээ хийх, төслийн үр дүнг үнэлэхэд хамтран оролцож, тухай бүрд санал, зөвлөгөө, дүгнэлт өгч ажиллах - ХИС-гийн орон нутаг дахь салбарын ажилтан, төслийн ажилтнуудтай хамтран ажиллаж, төслийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай баримт бичиг, хэрэгцээтэй мэдээллийг цаг хугацаанд нь шуурхай гарган өгч, шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллах - Төслийн үр дүнг түгээн дэлгэрүүлэх зорилгоор төслийн хүрээнд боловсруулсан сургалтын хөтөлбөр, гарын авлага, төслийн хүрээнд хүүхэд болон насанд хүрэгчдээс гарсан шинэлэг санаа зэргийг тогтвортой үргэлжлүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд бодлого, зохион байгуулалт, аргазүйн дэмжлэг үзүүлэх

		- Төслийн орон нутгийн ажилтны аюулгүй, хэвийн үйл ажиллагаа явуулахад тохирох ажлын өрөөгөөр хангахад дэмжлэг үзүүлэх
2	ТОНЗ-ийн гишүүн, Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга	- Зөвлөлийн хурал, төслийн бусад үйл ажиллагаанд идэвхтэй, тогтмол оролцох - Төслийн зорилго, зорилтыг ханган ажиллах орон нутгийн нэгдсэн төлөвлөгөөг гаргахад шаардлагатай мэдээ, мэдээлэл, дүрэм журмаар хангах - Төслийн үйл ажиллагааг Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөө болон нийгмийн салбаруудын төсөв, төлөвлөгөөнд тусгах, уялдаа холбоог хангаж ажиллах - Аймгийн бодлого, төлөвлөгөөтэй төслийн үйл ажиллагааг уялдуулах, аймгийн хэмжээнд сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэн ажиллах - ТОНЗ-ийн хурлаас гаргасан шийдвэрийг холбогдох хэлтэс албадаар дамжуулан үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
3	ТОНЗ-ийн гишүүн, Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсролын газрын дарга	- Зөвлөлийн хурал, төслийн бусад үйл ажиллагаанд идэвхтэй, тогтмол оролцох - ТОНЗ-ийн жилийн төлөвлөгөөг хянаж батлах, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцоход санал хүргэх - Төслийн хүрээнд бэлтгэгдсэн сургагч багш нарын шинэ арга зүйг аймгийн хэмжээнд үе шаттай түгээн дэлгэрүүлэх төлөвлөлт гарган ажиллах - Зорилтот сургуулиудын захирлуудын үр дүнгийн гэрээнд төслийг тогтвортой чанартай хэрэгжүүлэх талаар тодорхой заалтуудыг тусган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах - Зорилтот ЕБС-уудын бодлого, багшийн хөгжлийн төлөвлөгөөнд хүүхэд хамгааллын талаарх үзэл санааг тусгуулах, сургуулийн хамгааллын багийн оролцоог нэмэгдүүлэх талаар тогтмол зөвлөмж өгөх - Хүүхдийн санаачилсан бичил төслийн үйл ажиллагааг идэвхжүүлэхэд зорилтот сургуулиудын удирдлагуудтай хамтран дэмжлэг үзүүлж төслийн үзэл санааг сургуулиуд дээр нутагшуулан авч үлдэх - Эцэг эх, асран хамгаалагчийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлэх - Төслийн хүрээнд хамтран ажиллах ЕБС-уудын удирдлагууд болон бусад боловсон хүчнийг тогтвортой, үр дүнтэй ажиллуулахад дэмжлэг үзүүлэх - Төслийн хяналт, үнэлгээг хамтран зохион байгуулах, үнэлгээгээр гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бодлого зохицуулалтаар хангах - Төслийн талаарх мэдээллийг аймгийн боловсролын салбарын бүрэлдэхүүн байгууллагуудад болон эцэг

		эхчүүд, олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байдлаар байнга мэдээлж байх - Төслийн тогтвортой байдлыг хангах, төслийн аргачлал, үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, нутагшуулан авч үлдэхэд дэмжлэг үзүүлэх
4	ТОНЗ-ийн гишүүн, Засаг даргын дэргэдэх ХГБХХГ-ын дарга	- Зөвлөлийн хурал, төслийн бусад үйл ажиллагаанд идэвхтэй, тогтмол оролцох - ТОНЗ-ийн жилийн төлөвлөгөөг хянаж батлах, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцоход санал хүргэх - Шаардлагатай судалгаа, мэдээллийг шуурхай гаргаж өгөх - Аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн хурлуудаар төслийн ажлын явц, үр дүн, цаашдын тогтвортой байдлыг хангах, сайн туршлагуудыг танилцуулах, зөвлөмж хүргүүлэх - Гэр бүлийн хөгжлийн төвийн үйл ажиллагаатай төслийн үйл ажиллагааг уялдуулах - Төслийн хүрээнд бэлтгэгдсэн сургагч багш нарын шинэ арга зүйг аймгийн хэмжээнд үе шаттай түгээн дэлгэрүүлэх төлөвлөлт гарган ажиллах - Зорилтот хамтарсан багуудын нийгмийн ажилтнуудын сургуулийн хүүхэд хамгааллын багтай хамтран ажиллах оролцоог нэмэгдүүлэх, сайн туршлагыг баримтжуулах - Эцэг эх, асран хамгаалагчийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлэх - Төслийн хяналт, үнэлгээг хамтран зохион байгуулах, үнэлгээгээр гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бодлого зохицуулалтаар хангах - Төслийн талаарх мэдээллийг аймгийн хэмжээнд холбогдох байгууллагуудад болон эцэг эхчүүд, олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байдлаар байнга мэдээлж байх - Төслийн тогтвортой байдлыг хангах, төслийн аргачлал, үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, нутагшуулан авч үлдэхэд дэмжлэг үзүүлэх
5	ТОНЗ-ийн гишүүн, Аймгийн Засаг даргын хэвлэлийн албаны дарга	- Зөвлөлийн хурал, төслийн бусад үйл ажиллагаанд идэвхтэй, тогтмол оролцох - Төслийн хүрээнд хуримтлуулсан сайн туршлагыг сурталчлах - Төслийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг сар бүр бэлтгэн олон нийтэд хүртээмжтэй хэлбэрээр хүргэх
6	ТОНЗ-ийн гишүүн, Есөнбулаг сумын Засаг даргын тамгын газрын	- Зөвлөлийн хурал, төслийн бусад үйл ажиллагаанд идэвхтэй, тогтмол оролцох - Төслийн үйл ажиллагааг аймаг, сумын хөгжлийн бодлого, чиглэл болон хэрэгжиж буй бусад төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаатай уялдуулж ажиллах - ХИС-гийн орон нутаг дахь салбарын ажилтан,

	нийгмийн бодлогын мэргэжилтэн	төслийн ажилтнуудтай хамтран ажиллаж, төслийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай баримт бичиг, хэрэгцээтэй мэдээллийг цаг хугацаанд нь шуурхай гарган өгч, шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллах - Төслийн үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг аймагтаа зохион байгуулж, холбогдох талуудын идэвхтэй оролцоог ханган, захиргааны удирдлага, зохицуулалтаар дэмжиж ажиллах - Зорилтот хамтарсан багууд төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах үүрэг, чиглэл өгөх - Төслийн хэрэгжилтийн үр дүнг орон нутагтаа тогтвортой хэрэгжүүлэх, бусад сум, сургуулиуд, хамтарсан багуудад түгээн дэлгэрүүлэхэд санаачилгатай ажиллах, сайн туршлагуудыг баримтжуулах
7	ТОНЗ-ийн гишүүн, Шарга сумын Засаг дарга бөгөөд хамтарсан багийн ахлагч	- Зөвлөлийн хурал, төслийн бусад үйл ажиллагаанд идэвхтэй, тогтмол оролцох - Сумын хамтарсан баг, сургуулийн хамгааллын багийн үйл ажиллагааг дэмжин ажиллах - ТОНЗ-ийн жилийн төлөвлөгөөг хянаж батлах, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцоход саналаа хүргэх, санаачилга гаргах - Төслийн талаарх мэдээллийг сумын иргэд, сонирхогч талуудад нээлттэй, хүртээмжтэй байдлаар байнга мэдээлэх - Сумын бодлого, төлөвлөгөөтэй төслийн үйл ажиллагааг уялдуулах, аймгийн хэмжээнд сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, тогтвортой байдлыг хангах - Төслийн хэрэгжилтийн явцтай танилцах, хяналт-үнэлгээ хийх, төслийн үр дүнг үнэлэхэд хамтран оролцож, тухай бүрд санал, зөвлөгөө, дүгнэлт өгч ажиллах - Төслийн хэрэгжилтийн явцад сумын удирдлагуудын нэгдсэн уулзалт, зөвлөгөөнүүд, эцэг эх, олон нийтэд жилд 2 удаа хэрэгжилтийн тайланг танилцуулдаг байх - Төслийн тогтвортой байдлыг хангах, төслийн аргачлал, үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, нутагшуулан авч үлдэхэд дэмжлэг үзүүлэх
8	ТОНЗ-ийн гишүүн, Ерөнхий боловсролын сургуулийн захирал бөгөөд хүүхэд хамгааллын багийн ахлагч	- Зөвлөлийн хурал, төслийн бусад үйл ажиллагаанд идэвхтэй, тогтмол оролцох - Сургуулийн хамгааллын баг, сумын хамтарсан багийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, гишүүдийн ажлын уялдаа холбоо, оролцоо, хамтын ажиллагааг хангах - ТОНЗ-ийн жилийн төлөвлөгөөг хянаж батлах, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцоход санал хүргэх

		- Төслийн талаарх мэдээллийг сумын иргэд, сонирхогч талуудад нээлттэй, хүртээмжтэй байдлаар байнга мэдээлэх - Төслийн хэрэгжилтийн явцтай танилцах, хяналт-үнэлгээ хийх, төслийн үр дүнг үнэлэхэд хамтран оролцож, тухай бүрд санал, зөвлөгөө, дүгнэлт өгч ажиллах - Төслийн хэрэгжилтийн явцад бий болж байгаа сайн туршлагауудыг иргэд, олон нийт, хүүхдүүдэд жилд 2-оос доошгүй удаа танилцуулах - Төслийн тогтвортой байдлыг хангах, төслийн аргачлал, үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, нутагшуулан авч үлдэхэд дэмжлэг үзүүлэх
9	ТОНЗ-ийн нарийн бичгийн дарга, ХИС-гийн ГоА аймаг дахь төслийн ажилтан	- Зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг бүрэн хангах, тайлагнах, хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхэд нягт хамтран үр дүнг тооцон ажиллах - ТОНЗ-ийн жилийн төлөвлөгөөг хамтрагч байгууллагуудаас санал авч нэгтгэх, төлөвлөгөө боловсруулах, ТОНЗ-ийн гишүүдээс санал авч даргаар батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох - Төслийн орон нутаг дах бусад бүх үйл ажиллагааг төсөлд хамрагдаж буй талуудын хийх ажилд аргазүйн зөвлөгөө өгөх, мэдээ, мэдээллээр хангах, үр дүнг тооцон, ТОНЗ-ийн хуралд хэлэлцүүлэх, шийдвэр гаргуулах, хамтран хэрэгжүүлэх - Төслийн аймгийн зөвлөлийн дарга, гишүүдийг мэдээллээр шуурхай хангах, санал хүсэлтийг сонсох - ТОНЗ-ийн гишүүд болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдсэн сүлжээнд холбох, аргазүйгээр хангах - ТОНЗ-оос гарсан шийдвэр, саналуудыг төслийн багт хүргүүлж, шийдвэрлүүлэх, үр дүнг тайлагнан ажиллах - Төслийн хүрээнд хуримтлуулсан сайн туршлагыг тогтвортой үргэлжлүүлэх, салбаруудын хэмжээнд түгээхэд нөлөөлөх - Холбогдох бичиг баримтуудыг боловсруулж, хянуулан холбогдох газруудад шуурхай хүргүүлэх, хариу мэдээллийг цаг хугацаанд нь авах, нэгтгэх - Сайн туршлагауудыг судалж, дэлгэрүүлэх, нутагшуулан хэрэгжүүлэхэд манлайлан ажиллах - Төсөлтэй холбоотой аливаа гомдол, саналыг орон нутагт хүлээн авах тогтолцоог олон нийт, холбогдох талуудад нээлттэй мэдээлж, ирсэн санал гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэх